

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ 2 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2018 оны хоёрдугаар сарын 20-ны 15 цаг 10 минутад эхэлж, 16 цаг 15 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 1 цаг 05 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох, ахиулах тухай	Төрийн захиргааны 59 албан хаагчид зэрэг дэв олгуулах, ахиулахаар шийдвэрлэж, аймгийн Засаг даргад уламжлахаар болов.
2	<p>Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай</p> <p>-Нөөцийн зараар бүртгүүлсэн иргэдийг тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлэх</p> <p>-Нийгмийн даатгалын хэлтсийн Адаацаг сум хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх</p> <p>-Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх</p> <p>-Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх</p> <p>-Эрүүл мэндийн газрын Сувилахуй болон уламжлалт, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх</p>	<p>Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын байгаль орчны хяналтын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд төрийн жинхэнэ албан хаагч Дэмбэрэл овогтой Ганцацралыг, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Дэлгэрцогт сумын газрын даамлын албан тушаалд төрийн жинхэнэ албан хаагч Лувсандорж овогтой Хуланг, Хүнс, хөдөө аж ахуйн газрын Халдваргүй өвчин, эм био бэлдмэл, халдваргүйтгэл, бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтний албан тушаалд төрийн жинхэнэ албан хаагч Мөнхцэцэг овогтой Баянжаргалыг, Нийгмийн даатгалын хэлтсийн Адаацаг сум хариуцсан байцаагчийн албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 161 дүгээр тогтоолоор Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Сумъяа овогтой Цэлмэгмааг, Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 сарын 04-ний өдрийн 157 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Хадбаатар овогтой Баясгаланг, Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 173 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Жаргалсайхан овогтой Чулуунтогтохыг, Эрүүл мэндийн газрын Сувилахуй болон уламжлалт, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 173 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Санжаа овогтой Долгорсүрэнг тус тус нэр дэвшүүлж, шийдвэр, холбогдох материалыг тухайн байгууллагуудад нь хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>
3	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд мэргэшлийн шалгалт зарлах тухай	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын дэс түшмэлийн 3, туслах түшмэлийн 15 нийт 18 сул ажлын байранд мэргэшлийн шалгалт зарлуулахаар шийдвэрлэж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхээр болов.